



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/190-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.selenge@audit.gov.mn](http://www.selenge@audit.gov.mn)

Сүхбаатар сум

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа  
Утас: 70363040 Цахим хаяг: [enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Батмөнх  
Утас: 70363036 Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)

Аудитыг гүйцэтгэсэн: Их наяд аудит ХХК  
Захирал: Х.Ариунзул  
Утас: 99077062 Цахим хаяг: [ikhnayadaudit@gmail.com](mailto:ikhnayadaudit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

<b>1. АУДИТЫН ДҮГНЭЛТ</b>	<b>2</b>
<b>2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b>	<b>4</b>
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b>	<b>10</b>
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b>	<b>14</b>
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b>	<b>17</b>
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b>	<b>18</b>

### Товчилсон үгийн жагсаалт

<b>АДБОУС</b>	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
<b>БШУС</b>	Боловсрол, шинжлэх ухааны сайд
<b>БШУЯ</b>	Боловсрол, шинжлэх ухааны яам
<b>БЕГ</b>	Боловсролын ерөнхий газар
<b>БШУГ</b>	Боловсрол, шинжлэх ухааны газар
<b>НБББББ</b>	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
<b>НДШ</b>	Нийгмийн даатгалын шимтгэл
<b>МУЕА</b>	Монгол улсын ерөнхий аудитор
<b>ХХК</b>	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЦАГААННУУР  
СУМЫН 2 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ З.СЭЛЭНГЭ ТАНАА

2024.02.23 № СЭА-2024/190/МА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэг нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/324 дүгээр тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 1 дүгээр түвшинд үнэлэгдэж байгууллагын менежмент сайжруулахад 8,819.1 мянган төгрөг, ажилтан албан хаагчдад 16,378.2 мянган төгрөг, нийт 25,197.3 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

### Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар

013020208

тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуу ж байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 83.9 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)</b>	<b>62,178,017.08</b>	<b>208,633,581.06</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>11,042,590.08</b>	<b>122,267,065.06</b>
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	11,042,590.08	122,267,065.06
31210	Төгрөг	11,042,590.08	122,267,065.06
31211	Төрийн сангийн харилцах	11,042,590.08	122,267,065.06
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>51,135,427.00</b>	<b>86,366,516.00</b>
35410	Бичиг хэргийн материал	39,500.00	39,500.00
35420	Аж ахуйн материал	40,793,887.00	78,755,257.00
35440	Түлш, шатах тослох материал	5,133,000.00	2,283,750.00
35460	Хүнсний материал	953,600.00	1,100,160.00
35470	Бусад хангамжийн материал	4,215,440.00	4,187,849.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)</b>	<b>1,874,875,776.39</b>	<b>1,822,279,748.37</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,874,875,776.39</b>	<b>1,822,279,748.37</b>
392	Биет хөрөнгө	1,870,681,776.39	1,818,085,748.37
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,907,499,774.00	1,907,499,774.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(86,176,117.05)	(128,708,289.57)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	40,253,518.00	46,239,318.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(20,142,236.35)	(29,456,134.56)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	45,467,941.80	46,998,841.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	(19,274,242.09)	(27,278,334.91)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,500,860.00	3,500,860.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(700,171.92)	(962,736.39)
393	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>4,194,000.00</b>	<b>4,194,000.00</b>
39303	Бусад биет бус хөрөнгө	4,194,000.00	4,194,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)</b>	<b>1,937,053,793.47</b>	<b>2,030,913,329.43</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)</b>	-	<b>2,837,510.00</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	2,837,510.00
41300	<b>Өглөг</b>		2,837,510.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		2,587,510.00
4136	<b>Бусад өглөг</b>	-	250,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	250,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)</b>	<b>1,937,053,793.47</b>	<b>2,028,075,819.43</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,937,053,793.47	2,028,075,819.43
51100	ЗГ-ын оруулсан капитал /ЗГ-ын сан/ орон нутгийн сан	4,194,000.00	4,194,000.00
511001	Өмч: төрийн өмч	4,194,000.00	4,194,000.00
51200	Хуримтлагдсан үр дүн	1,932,859,793.47	2,023,881,819.43
51210	Өмнөх үеийн үр дүн	1,932,859,793.47	1,932,859,793.47
51220	Тайлант үеийн үр дүн	-	91,022,025.96
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)</b>	<b>1,937,053,793.47</b>	<b>2,030,913,329.43</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,526,771,895.44</b>	<b>824,792,890.52</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,984,544,488.20</b>	<b>32,475,470.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	1,984,544,488.20	32,780,470.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,984,544,488.20	32,475,470.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	200,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого		105,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,984,544,488.20	32,170,470.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>542,227,407.24</b>	<b>792,317,420.52</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	464,405,800.00	750,537,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	464,405,800.00	750,537,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,250,000.00	1,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,250,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,000,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>76,571,607.24</b>	<b>40,780,420.52</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	76,571,607.24	40,780,420.52
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>589,718,101.97</b>	<b>733,770,864.56</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>589,718,101.97</b>	<b>733,770,864.56</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	589,718,101.97	717,392,664.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	357,886,539.00	449,918,176.00
210101	Үндсэн цалин	266,161,735.00	334,595,720.00
210102	Нэмэгдэл цалин	76,011,911.00	97,472,606.00
210104	Урамшуулал	15,712,893.00	17,849,850.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх шимтгэл	45,462,462.16	59,545,399.02
210201	Тэтгэврийн даатгал	30,890,646.55	41,014,832.84
210202	Тэтгэмжийн даатгал	3,758,960.14	4,825,274.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,909,727.93	3,662,333.84
210204	Ажилгүйдлийн даатгал	709,126.26	898,407.45
210205	Эрүүл мэндийн даатгал	7,194,001.28	9,144,550.53
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>30,564,074.00</b>	<b>40,159,670.52</b>
210301	Гэрэл, цахилгаан	7,848,474.00	8,806,420.52
210302	Түлш, халаалт	16,235,600.00	20,843,250.00
210303	Цэвэр, бохир ус	6,480,000.00	10,510,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	-
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>70,577,100.00</b>	<b>82,754,100.00</b>
210502	Хоол, хүнс	70,577,100.00	82,754,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,496,100.00</b>	<b>3,470,000.00</b>
210604	Урсгал засвар	3,496,100.00	3,470,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>962,000.00</b>	<b>1,259,900.00</b>
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	962,000.00	1,259,900.00

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>80,769,826.81</b>	<b>80,285,419.02</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,985,842.00	14,063,941.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,801,200.00	6,139,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	59,982,784.81	60,081,878.02
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	<b>16,378,200.00</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	16,378,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	16,378,200.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>1,937,053,793.47</b>	<b>91,022,025.96</b>
<b>5</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	-
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ</b>	-	-
<b>6</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (6)=(4-5)</b>	-	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>1,937,053,793.47</b>	<b>91,022,025.96</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>542,227,407.24</b>	<b>792,622,420.52</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>305,000.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	-	305,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	305,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	200,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	-	105,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>542,227,407.24</b>	<b>792,317,420.52</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	464,405,800.00	750,537,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	464,405,800.00	750,537,000.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,250,000.00</b>	<b>1,250,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,250,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,000,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>76,571,607.24</b>	<b>40,780,420.52</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	76,571,607.24	40,780,420.52
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>531,184,817.16</b>	<b>673,881,245.54</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>531,184,817.16</b>	<b>673,881,245.54</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>531,184,817.16</b>	<b>657,503,045.54</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	357,886,539.00	449,668,176.00
210101	Үндсэн цалин	266,161,735.00	334,345,714.00
210102	Нэмэгдэл цалин	76,011,911.00	97,472,612.00
210104	Урамшуулал	15,712,893.00	17,849,850.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх шимтгэл</b>	<b>45,462,462.16</b>	<b>59,545,399.02</b>
210201	Тэтгэврийн даатгал	30,890,646.55	41,014,832.84
210202	Тэтгэмжийн даатгал	3,758,960.14	4,825,274.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,909,727.93	3,662,333.84
210204	Ажилгүйдлийн даатгал	709,126.26	898,407.45
210205	Эрүүл мэндийн даатгал	7,194,001.28	9,144,550.53
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>35,697,074.00</b>	<b>37,310,420.52</b>
210301	Гэрэл, цахилгаан	7,848,474.00	8,806,420.52
210302	Түлш, халаалт	19,126,100.00	19,964,000.00

210303	Цэвэр, бохир ус	8,722,500.00	8,540,000.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>71,212,600.00</b>	<b>80,522,050.00</b>
210502	Хоол, хүнс	71,212,600.00	80,522,050.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,496,100.00</b>	<b>3,470,000.00</b>
210604	Урсгал засвар	3,496,100.00	3,470,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>962,000.00</b>	<b>1,259,900.00</b>
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	962,000.00	1,259,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,468,042.00	25,727,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,968,042.00	21,947,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,500,000.00	3,779,600.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	<b>16,378,200.00</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	16,378,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	16,378,200.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>11,042,590.08</b>	<b>118,741,174.98</b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	-	<b>7,516,700.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	7,516,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	7,516,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	7,516,700.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	<b>(7,516,700.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>11,042,590.08</b>	<b>111,224,474.98</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	11,042,590.08
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	122,267,065.06

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны үр дүн
А	1	2	3	4
<b>2021 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>4,194,000.00</b>	-	<b>1,957,644,845.20</b>	<b>1,961,838,845.20</b>
НББ-ийн бодлогын өөрчлөлт	-	-	(1,961,838,845.20)	(1,961,838,845.20)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
ҮХ-ийн өсөлт, бууралт	-	-	-	-
ҮХ-ийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	<b>1,937,053,793.47</b>	<b>1,937,053,793.47</b>

<b>2022 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>4,194,000.00</b>	-	<b>1,932,859,793.47</b>	<b>1,937,053,793.47</b>
НББ-ийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
ҮХ-ийн өсөлт, бууралт	-	-	-	-
ҮХ-ийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	<b>91,022,025.96</b>	<b>91,022,025.96</b>
<b>2023 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>4,194,000.00</b>	-	<b>2,023,881,819.43</b>	<b>2,028,075,819.43</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>802,884,600.00</b>	<b>673,881,245.54</b>	<b>129,003,354.46</b>	<b>83.9</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	802,884,600.00	673,881,245.54	129,003,354.46	83.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	786,506,400.00	657,503,045.54	129,003,354.46	83.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	550,761,400.00	449,668,176.00	101,093,224.00	81.6
210101	Үндсэн цалин	362,416,500.00	334,345,714.00	28,070,786.00	92.3
210102	Нэмэгдэл	170,410,100.00	97,472,612.00	72,937,488.00	57.2
210104	Урамшуулал	17,934,800.00	17,849,850.00	84,950.00	99.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,825,100.00	59,545,399.02	17,279,700.98	77.5
210201	Тэтгэврийн даатгал	52,241,200.00	41,014,832.84	11,226,367.16	78.5
210202	Тэтгэмжийн даатгал	6,146,100.00	4,825,274.36	1,320,825.64	78.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,916,500.00	3,662,333.84	1,254,166.16	74.5
210204	Ажилгүйдлийн даатгал	1,229,200.00	898,407.45	330,792.55	73.1
210205	Эрүүл мэндийн даатгал	12,292,100.00	9,144,550.53	3,147,549.47	74.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,835,000.00	37,310,420.52	524,579.48	98.6
210301	Гэрэл, цахилгаан	9,805,000.00	8,806,420.52	998,579.48	89.8
210302	Түлш, халаалт	17,000,000.00	17,994,000.00	(994,000.00)	105.8
210303	Цэвэр, бохир ус	11,030,000.00	10,510,000.00	520,000.00	95.3
2105	Нормативт зардал	83,163,400.00	80,522,050.00	2,641,350.00	96.8
210502	Хоол, хүнс	83,163,400.00	80,522,050.00	2,641,350.00	96.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,470,000.00	3,470,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	3,470,000.00	3,470,000.00	-	100.0

2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,259,900.00	1,259,900.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,259,900.00	1,259,900.00	-	100.0
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	33,191,600.00	25,727,100.00	7,464,500.00	77.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,412,000.00	21,947,500.00	7,464,500.00	74.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,779,600.00	3,779,600.00	-	100.0
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	16,378,200.00	16,378,200.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,378,200.00	16,378,200.00	-	100.0
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	7,516,700.00	(7,516,700.00)	-
	Дотоод эх үүсвэрээр	-	7,516,700.00	(7,516,700.00)	-
1	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	802,884,600.00	792,622,420.52	(10,262,179.48)	98.7
131	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	762,104,179.48	751,537,000.00	(10,567,179.48)	98.6
131001	Улсын төсвөөс санхүүжих	762,104,179.48	751,537,000.00	(10,567,179.48)	98.6
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого				
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө				
132	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	40,780,420.52	40,780,420.52	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	40,780,420.52	40,780,420.52	-	100.0
133	<b>ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС</b>				
134	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>				
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		305,000.00	(305,000.00)	
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		200,000.00	(200,000.00)	
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		105,000.00	(105,000.00)	
124	<b>БУСАД ЭХ ҮҮСВЭР</b>				
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		11,042,590.08	(11,042,590.08)	

31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		122,267,065.06	(122,267,065.06)	
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО				100.0
3	Төсвийн байгууллага	1	1		100.0
4	Төсвөөс гадуур байгууллага	1	1		100.0
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	32	32		100.0
6	Удирдах ажилтан	1	1		100.0
7	Гүйцэтгэх ажилтан	12	12		100.0
8	Үйлчлэх ажилтан	21	21		100.0
10	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	198	198		100.0
14	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	198	198		100.0
15	Төрийн өмчит СӨБ байгууллага	198	198		100.0

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэг нь “Суралцагч бүрийн сурлагын хоцрогдлыг арилгая” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.

Тус байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Хүүхэд бүрийг тэгш хамруулан сургах нөхцөлийг бүрдүүлж, сурлагын хоцрогдлыг арилгах;
- Хичээл сургалтын үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэн, цахим сан болон даалгаврын санг бүрдүүлж ашиглах;
- Багш бүр сургалтын арга хэлбэр, заах арга зүйгээ оновчтой сонгон заах;
- Багш, сурагч, эцэг эх, асран хамгаалагчдын хамтын ажиллагааг сайжруулах;

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Боловсролын ерөнхий хууль 2023 оны 07 дугаар сарын 07-нд батлагдсан,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,

- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд: "Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом, наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах" чиглэлийг хүргүүлсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэг нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 2,030,913.3 мянган төгрөг болж өмнөх оноос 93,859.5 мянган төгрөгөөр буюу 4.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	11,042.6	122,267.1	111,224.5
Авлага	-	-	-
Бараа материал	51,135.4	86,366.5	35,231.1
Үндсэн хөрөнгө	1,874,875.8	1,822,279.8	(52,596.0)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,937,053.8</b>	<b>2,030,913.3</b>	<b>93,859.5</b>
Өр төлбөр	-	2,837.5	2,837.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,937,053.8	2,028,075.8	91,022.0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,937,053.8</b>	<b>2,030,913.3</b>	<b>93,859.5</b>

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн данс 122,267.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 7.9-д заасны дагуу тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлтийг төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнасантай холбоотой байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 86,366.5 мянган төгрөг болж 35,231.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 124,797.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, БШУЯ-аас 32,170.5 мянган төгрөгийн бараа материал шилжүүлэн авсан болон 121,736.5 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалжээ.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,822,279.8 мянган төгрөг болж 52,596.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 7,516.7 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 60,112.7 мянган төгрөгийн элэгдэл байгуулснаас шалтгаалсан байна.
- Өр төлбөрийн дансанд 2,837.5 мянган төгрөгийн өр тайлагнагдсан нь “Ноён уулын хишиг” ХХК-д хүнсний материалын өглөг үүссэнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 590,196.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 46,728.2 мянган төгрөг, нийт 636,924.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвийн санхүүжилтийг 171,383.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 5,423.2 мянган төгрөгөөр бууруулан тооцож улсын төсвөөс 750,537.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 41,305.0 мянган төгрөг, урьд оны дансны үлдэгдлээс 11,042.6 мянган төгрөгийг төвлөрүүлэн нийт 802,884.6 мянган төгрөгийг зарцуулахаар баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 762,104.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 40,780.4 мянган төгрөг, нийт 802,884.6 мянган төгрөгийн эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд захиран зарцуулахаар төлөвлөгдсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 673,881.2 мянган төгрөг буюу 83.9 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 101,093.2 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 17,584.7 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 524.6 мянган төгрөг, нормативт зардлыг 2,641.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 7,464.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/							
д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71801 Сургуулийн өмнөх боловсрол	1	81605- Эрүүл мэндийг дэмжих	1,889.80	1,637.00	252.8	86.6
		2	81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол	78,292.60	69,967.35	2,641.30	89.4
		3	81816- Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	4,603.10	4603.1	4,505.00	100.0
		4	81823- Боловсролын байгууллагын багш ажилчдын	1,889.80	1,889.80	0	100.0

		мэргэжил дээшлүүлэх				
	5	81832- Нүүдлийн бүлэгт хамаарах	19,558.80	19,558.80	0	100.0
	6	81834- Боловсролын стандарт сургалт	427,858.60	338,954.43	88,904.20	79.2
	7	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	227,486.90	196,490.35	32,480.40	86.4
	9	80111- Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	41,305.00	40,780.42	524.58	98.7
	<b>Нийт</b>		<b>802,884.6</b>	<b>673,881.2</b>	<b>129,308.3</b>	<b>83.9</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэг нь 2023 онд улсын төсвийн хөрөнгөөр хүүхдийн хоол хүнс худалдан авахаар 83,163.4 мянган төгрөг төсөвлөсөн байна.

Тайлант онд худалдан авах ажиллагааны урилгыг [tender.gov.mn](http://tender.gov.mn) цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааны шалгаруулалтад "Ноён уулын хишиг" ХХК оролцож, гүйцэтгэгчээр шалгаран гэрээ байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу "Их наяд аудит" ХХК-ийн аудитор Х.Ариунтуяа гүйцэтгэж, хяналтыг захирал Х.Ариунзул, дараагийн шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Их наяд аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 09 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 589,718.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,845.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн системд нийт мэдээлбэл зохих 28 төрлийн 159 мэдээлэл байршуулахаас тус байгууллага нь мэдээллийг цаг хугацаанд нь ил тод, бүрэн байршуулж мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

##### 1. Бусад хууль тогтоомжтой холбоотой асуудал

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд 2023 оны санхүүгийн тайлангийн завсрын аудитаар 5,545.4 мянган төгрөгийн 5 алдаа илэрснээс жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад 2,501.4 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 3,044.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өглөө.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй зөрчлийг давтан гаргахгүй талаар өгсөн 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1		1		100.0
<b>Нийт дүн</b>	<b>1</b>		<b>1</b>		<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

2. Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үндсэн хөрөнгийн тооллого хийж, биет тест хэрэгжүүлэх горимыг бүрэн хэрэгжүүлээгүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,501.4 мянган төгрөгийн алдаа 3 алдаа илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас цахим баримтгүйгээр 2,310.5 мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэсэн.
2. Цалингийн зардал, түүнтэй холбоотой 190.9 мянган төгрөгийн ажил гүйлгээг журналд мөнгөн сууриар бүртгэж, тайлагнасан.
3. Авлага, өр төлбөрийг журналд тусгахдаа харилцагчийн нэрийг буруу сонгож илүү дутуу илэрхийлсэн байна.

Аудитаар нийт **8,068.9** мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илрүүлж, 2 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өглөө.

### 5.1 Албан шаардлага

1. Батлагдсан цалингийн зардлаас 4 албан хаагчид "Байгууллагын аварга"-аар шалгарсан гэх үндэслэлээр шагналын зардалд 5,231.4 мянган төгрөгийг гүйлгэн, зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор илэрхийлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэх.

2. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас "Ноён уулын хишиг" ХХК-д хүнсний материалын 2,837.5 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдах, төлбөр тооцоог урьдчилан хянах замаар авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Цагааннуур сумын 1 дүгээр цэцэрлэгийн үндсэн орон тоонд нягтлан бодогчоор ажиллаж буй О.Орхончимэгийг тус цэцэрлэгт зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээгээр нягтлан бодогчоор ажиллуулан, цалинжуулж / үндсэн цалингийн 100.0 хувиар тооцож / байгаа нь дараах хуулиудыг тус тус зөрчиж байна. Үүнд:

- Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх "Төрийн албан хаагч дараах нийтлэг үүрэг хүлээнэ" 37.1.17: "Үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил, үүрэг эрхлэхгүй байх",
- 38 дугаар зүйлийн 38.1 дэх "Төрийн албан хаагч дараах нийтлэг эрх эдэлнэ", 38.1.6: "Багшлах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх", 38.1.7: "Хууль тогтоомжоор хориглоогүй, албан тушаалын ашиг сонирхолд харшлахгүй арга хэлбэрээр хувийн аж ахуй эрхлэх...",
- Хөдөлмөрийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3 дахь "Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээтэй ажилтны нийт ажлын цаг энэ хуулийн 84.4 -т заасан ажлын цагийн дээд хязгаарт багтах ёстой бөгөөд үүнд ажилтан, үндсэн болон зэрэгцсэн ажил олгогч тус тус хяналт тавина", 84 дүгээр зүйлийн 84.4 дэх "Долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна. Өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна" зэрэг.

1.2 Өгсөн зөвлөмж: 2 байгууллагад зэрэгцээ хөдөлмөрөөр нягтлан бодогчийн албан тушаал эрхлүүлж буй зөрчлийг таслан зогсоож, зайлшгүй тохиолдолд цалинг өдрийн 4 цагаар бодож, 50.0 хувиас хэтрүүлэхгүй байх.

## 2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ балансын анхны өртгөө бүрэн нөхсөн 2 нэр төрлийн 3,044.0 мянган төгрөгийн дансны үнэ бүхий хөрөнгийг шийдвэрлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" гэж заасантай нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ өртгөө нөхсөн, ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн шийдвэрлүүлэх, хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5<sup>2</sup> дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг

<sup>2</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж	
							Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цахим баримтгүй худалдан авалт гүйцэтгэсэн	1	2,310.5			1	2,310.5	1	2,310.5				
Цалингийн зардлыг журналд мөнгөн сууриар хөтөлж, бүртгэсэн	1	190.9			1	190.9	1	190.9				
Авлага, өр төлбөрийг журналд тусгахдаа харилцагчийн нэрийг буруу сонгож илүү дутуу илэрхийлсэн байна.	1				1		1					
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>2,501.4</b>	<b>1</b>		<b>3</b>	<b>2,501.4</b>	<b>3</b>	<b>2,501.4</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй.	1	5,231.4			1	5,231.4						
Өр төлбөр үүсгэсэн.	1	2,837.5			1	2,837.5						
Нягтлан бодогчийг зэрэгцээ хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулсан	1	-					1	-				
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг шийдвэрлүүлээгүй	1	-					1	-				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>8,068.9</b>			<b>2</b>	<b>8,068.9</b>	<b>2</b>	<b>-</b>				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				/мянган төгрөгөөр/	
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Нийт дүн</b>								